

## ТАНАЙ СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?

Суманд шинээр ирсэн иргэдэд Орхон гол дагуу хүнсний ногоо тариалах талбай эзэмшүүлэх, Сэлэнгэ мөрөн дагуу жимс жимсгэнэ тариалах талбай, газар олгох боломжтой.

Эрчимжсэн үхрийн аж ахуй эрхлэх, фермерийн аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдэд газар эзэмшүүлж, өрхийн тариалан эрхлэх боломжоор ханган хамтран ажиллана.



# НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ:

БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1931 оны 2-р сарын 7-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Богдхан уулын аймгийн Зүүнбүрэн хан уулын хошуунаас Хушаат сумыг байгуулжээ. 1956-1959 онд Төв аймагт харьяалагдаж байв. 1960 онд Сэлэнгэ аймагт шилжин ирээд татан буугдаж Дархан сум, Сант сум, Баруунбүрэн сумдад харьяалагдаж байсан ба БНМАУ-н Сайд нарын зөвлөлийн 1986 оны 329-р тогтоолоор Хушаат сум дахин байгуулагдаж, Ардын их хурлын тэргүүлэгчдийн 1987 оны 121 дүгээр зарлигаар Хушаат сумын хилийн цэсийг тогтоон баталж Энхталын сангийн аж ахуй байгуулагдсан.



88218414



<http://khushaat.se.gov.mn/>



Хушаат сум Даагат, Мөнхтолгой гэсэн 2 багтай. Нийт 580 өрхийн 2120 хүн амтай. 50 аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа эрхэлдэг.

Сумын гол үйлдвэрлэл газар тариалан, мал аж ахуйн салбар бөгөөд төмсний эрт болцын нутагшсан сорт "Сэлэнгэ-8", "Казакийн цагаан толгойт" үүлдрийн цөм сүргийн үхэр Хушаат сумын брэнд бүтээгдэхүүнүүд юм.



Хушаат сум Орхон гол, Сэлэнгэ мөрний дунд оршдог. Газар тариаланд нэн тохиромжтой, үржил шимтэй хөрстэй. Газар тариалан тэр дундаа төмс хүнсний ногооны усалгаатай тариалан эрхлэх өргөн боломжтой. Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 20 гаруй аж ахуйн нэгж, 100 гаруй иргэн байна. Газар тариалангийн аж ахуйн нэгж, малын тэжээлийн түүхий эдэд түшиглэн эрчимжсэн мал аж ахуй, мах сүүний чиглэлийн Казакийн цагаан толгойт үүлдрийн үхэр өсгөж, үржлийн мал борлуулах болон сайн чанарын эрүүл малын мах зах зээлд нийлүүлдэг онцлогтой.

Дархан хотоос 30 км зайд оршдог. Дархан Сэлэнгийн авто замаас 20 км, төмөр замын 96-р өртөөнөөс 7 км зайтай. Дэд бүтцэд ойрхон. Суманд үйлдвэрлэсэн малын гаралтай болон газар тариалангийн бүтээгдэхүүнийг борлуулах зах зээл болох Дархан хоттой хамгийн ойр байдаг давуу талтай.

#### ТУС СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Гадаргын ус буюу голоос суваг татах аргаар усалгаатай тариалан, төмс хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж Дархан хотын төмс хүнсний ногооны хэрэгцээний тодорхой хувийг хангадаг сум болох мөн эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуй, усалгаатай газар тариалан, төмс хүнсний ногооны үйлдвэрлэл

эрхлэхэд нэн тохиромжтой бөгөөд өрх бүр байнгын орлоготой чинээлэг амьдрах боломжтой.

Бүрэнгийн нуруу, Амарбаясгалант хийд орчмын байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх, Ар могой, Асмалжингийн рашааныг түшиглэсэн амралт сувилал байгуулж амрагч жуулчдыг татах боломжтой.

Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд тэжээлийн нөөц ихтэй.

Сонирхогчдын загасчлал, усан аялал, байгалийн аялал жуулчлал хөгжих боломжтой.

Мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах анхан шатны үйлдвэр байгуулж зах зээлд нийлүүлэх хэрэгцээ шаардлагатай.



**ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ БОЛОН ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ:**

Соёл, спортын цогцолборын шинэ барилгын ажлын зураг төсвийг захиалан хийлгэж улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.

Сумын төвийг Дархан Сэлэнгийн авто замтай холбох 19,4 км хатуу хучилттай авто замын 15,6 тэрбум төгрөгийн төсөвтэй төслийн зураг төсөв хийгдсэн.

2024 оны улсын төсөвт уг авто замын эхлэл болох сумын төв доторх 3 км замын төсөв тусгагдсан.

Усалгааны систем тавих боломжтой талбайн судалгаа хийгдсэн. Улс, аймгийн төсөв, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар усалгаатай талбайн хэмжээ нэмэгдэнэ.

